



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/10.

Өлгий

Г Хөрөнгө зарцуулах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль-ийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/759 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Еба Их сургуулийн нарийн мэргэжлийн эмч нарын багтай хамтран манай аймгийн ард иргэдийн дунд зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэгийн үед гарсан орчуулагчийн зардалд 1500.0 мянган төгрөг, хоолны зардалд 5584.0 мянган төгрөг, ачаа тээврийн зардалд 350.0 мянган төгрөг, нийт 7434.0 (долоон сая дөрвөн зуун гучин дөрвөн мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 7,434,000 (долоон сая дөрвөн зуун гучин дөрвөн мянга) төгрөгийг холбогдох анхан шатны баримтуудыг үндэслэн бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (С.Еншигүлд)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүү, хяналт-шинжилгээ, мэдээллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (А.Ерганат)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН

